



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 4469

Улаанбаатар хот

Г Т

Төгсөлтийн дараахь гадаад сургалтын  
тэргүүлэх чиглэл батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 119 дүгээр тушаалын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн ажилтныг 2016-2019 онд улсын төсвийн санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулахад баримтлах зарчмыг нэгдүгээр, сургалтын төргүүлэх чиглэлийг хосрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан баримтлах зарчим, тэргүүлэх чиглэлийн дагуу төрийн болон орон нутгийн өмчйт эрүүл мэндийн байгууллагын ажилтны сургалтын үйл ажиллагааг холбогдох журмын дагуу ил тод, нээлттэй зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, тушаалыг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Стратегийн бодлого толовлолтийн газар /Р.Оюунханд/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан тэргүүлэх чиглэлд багтаагүй зарим шаардлагатай чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг байгууллагын гадаад хамтын ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд өндөр хөгжилтэй оронд сургалтад хамруулах талаар идэвхитэй ажиллахыг нийт эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтийн хөгжлийн зөвлөл /С.Ламбаа/-д даалгасугай.

5 Тушаалын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, гадаад сургалтын үр дүн, санхүүжилтийн үр ашгийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080600

Эрүүл мэнд, спортын сайдын 2016  
оны 119 дугаар сарын 11-ны өдрийн  
дүгээр тушаалын нэгдүгээр  
хавсралт

**Эрүүл мэндийн ажилтныг 2016-2019 онд улсын төсвийн зардлаар гадаадын  
өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулахад  
баримтлах зарчим**

“Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах  
журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2014 оны 119 дүгээр тушаалын  
гуравдугаар бүлэгт зааснаас гадна доорх зарчмыг баримтлана. Үүнд:

1. Монгол улсад оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчин эмгэгийн оношилгоо,  
эмчилгээний чиглэлээр нэн түрүүнд сургалтыг зохион байгуулах;
2. Гадаад сургалтын агуулга, хөтөлбөр нь шинэ технологи эзэмшүүлэхэд  
чиглэгдэх;
3. Гадаад сургалтын (танилцах аялалд хамаарахгүй) хугацаа нь 1 сараас доошгүй  
байх;
4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эрүүл мэндийн ажилтанг төрөлжсөн  
мэргэшлийн чиглэлээр, бусад эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн  
ажилтанг үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад  
хамруулах;
5. Тэргүүлэх чиглэлийн дагуу их эмчээс гадна сувилагч, тусгай мэргэжилтэн,  
бусад шаардлагатай мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах;
6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас зардлыг нь хариуцан эмч,  
мэргэжилтнүүдээ сургах хүсэлт гаргасан тохиолдолд суралцах байгууллагатай  
холбох, төрийн болон орон нутгийн өмчтэй эрүүл мэндийн байгууллагын  
эмнэлгийн мэргэжилтэнтэй адил нөхцлөөр сургах боломжийг бүрдүүлэхэд  
дэмжлэг үзүүлэх;
7. Зөвхөн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрсөн чиглэлийн дагуу  
танилцах аялалыг зохион байгуулах;
8. Эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараахь гадаад сургалтын тухайн жилийн  
батлагдсан зардлын тус бүр 20 хүртэлх хувийг үндсэн мэргэшлийн чиглэлийн  
сургалт болон танилцах аялалд зарцуулах;
9. Тэргүүлэх чиглэлд багтаагүй боловч төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн төв,  
бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэгт шинээр нэвтэрсэн болон  
жилийн дотор шинээр нэвтрүүлэх нь тодорхой болсон оношилгоо, эмчилгээний  
технологитой холбоотойгоор тэргүүлэх чиглэлд багтаагүй бусад төрөлжсөн  
мэргэшлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтийг сургах асуудлыг Сайд, Төрийн  
нарийн бичгийн даргын зөвшөөрсөнөөр тухай бүр шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн спортын сайдын 2016  
оны 05 дугаар сарын 11-ны өдрийн  
1169. дүгээр тушаалын хоёрдугаар  
хавсралт

Эрүүл мэндийн ажилтныг 2016-2019 онд **УЛСЫН ТӨСВИЙН ЗАРДЛААР** гадаадын  
өндөр хөгжилтэй оронд төгсөлтийн дараахь сургалтад хамруулах тэргүүлэх  
чиглэл

**I. Эх барих, эмэгтэйчүүдийн эмгэг судлал**

1. Үргүйдлийн оношилгоо, эмчилгээ (өндгөвчний дутуу хөгжил)
2. Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ

**II. Эрэгтэйчүүдийн эмгэг судлал**

1. Эрэгтэйчүүдийн үрийн сувгийн эмгэгээс үүдсэн үргүйдэл

**III. Хүүхдийн эмгэг судлал**

1. Ургийн оношилгоо, эмчилгээний арга (мэс заслын болон мэс заслын бус)
2. Дутуу нярайн эмгэгийн оношилгоо, эмчилгээ
3. Аутизмын оношилгоо, эмчилгээ
4. Хүүхдийн хэт хөдөлгөөнт ба анхаарал суларлын хам шинж өвчний оношилгоо, эмчилгээ

**IV. Яаралтай тусламж/ гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

1. Нярай хүүхдийн яаралтай тусламж (ясанд хатгаж эм хийх технологи)

**V. Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ судлал:**

1. Нярай хүүхдийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ
2. Халдварт өвчний үеийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ
3. Зүрх, мэдрэлийн болон эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын үеийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ

**VI. Халдварт өвчин судлал**

1. Олон эмэнд тэсвэртэй сурьеэгийн оношилгоо, эмчилгээ
2. Шинээр тархаж буй халдварт өвчиний оношилгоо, эмчилгээ (MERS г.м.)

**VII. Мэдрэлийн эмгэг судлал**

1. Тархины цусан хангамж аажмаар даамжран дутагдах өвчиний эмчилгээ

**VIII. Зүрх судасны эмгэг судлал**

1. Үе мөчний эмгэгийн оношилгоо, эмчилгээ

**IX. Сэтгэцийн эмгэг судлал**

1. Сэтгэл засал
2. Өтлөлтийн үеийн сэтгэцийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ
3. Донтох эмгэгийн оношилгоо, эмчилгээ

## **X. Мэс засал судлал**

1. Зүрхний мэс засал (гол судасны цулхэнг графт стентээр эмчлэх)
2. Хүүхэд (нярай)-ийн зүрхний мэс засал (хавсарсан хүнд хэлбэрийн гажиг)
3. Хүүхдийн бөөрний дурангийн мэс засал
4. Мэдрэлийн мэс засал (Паркинсон, эпилепси зэрэг өвчний үеийн стереотакс мэс засал, гүрээний ба нурууны артерийн нарийсал, бөглөрлийн үеийн мэс засал, уртавтар тархины эмгэгийн мэс засал, тархины суурь хэсэг ба багана бүтцийн болон ховдлын хавдрын мэс засал, )

## **XI. Гэмтэл, согог-засал судлал**

1. Төрөлхийн болон шалтгаан тодорхойгүй нуруу мурийлт, хүнд хэлбэрийн нурууны гулсалтын эмчилгээ
2. Их талбай хамарсан түлэгдэл, хөлдөлтийн дараах нөхөн сэргээх мэс засал
3. Хүүхдийн гэмтэл, согог засал
4. Гар сарвууны бичил мэс засал

## **XII. Хавдар судлал**

1. Хорт хавдрын молекул генетикийн оношилгоо, эмчилгээ
2. Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал
3. Толгой, хүзүүний болон цээжний хөндийн хавдрын нөхөн сэргээх мэс засал
4. Хүүхдийн хавдар судлал
5. Тархи, нугасны хавдрын гамма туяа эмчилгээ

## **XIII. Эрүү нүүрний мэс засал**

1. Уруулын сэтэрхийн мэс заслын дараа хамар хэлбэржүүлэх эмчилгээний арга
2. Хүүхдийн төвөнхийн мэс засал

## **XIV. Нүдний эмгэг судлал**

1. Нүдний мэс засал (эвэрлэг, торлог, шилэнцэрийн хүнд хэлбэрийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ)

## **XV. Чих, хамар, хоолойн эмгэг судлал**

1. Чихний эмгэгийн үеийн бичил мэс засал
2. Сонсголын мэдрэлийн хавдрын мэс засал
3. Вегенерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн оношилгоо, эмчилгээ
4. Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн оношилгоо, эмчилгээ

## **XVI. Цусны эмгэг судлал**

1. Цусны хорт хавдрын эмчилгээ, оношилгоо

## **XVII. Арьсны эмгэг судлал**

1. Үсний эмгэг судлал (үс уналт, халцаарлын үеийн оношилгоо, эмчилгээ)

## **XVIII. Насжилт судлал**

1. Насжилт судлал

## **XIX. Эмнэлзүйн эмгэг судлал**

1. Молекул генетикийн шинжилгээ
2. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах эмгэг судлалын шинжилгээ

3. Хүүхдийн эмгэг судлалын шинжилгээ
4. Иммуногистохимиийн эмгэг судлалын шинжилгээ
5. Гемофилтэй өвчтөнүүдэд VIII, IX дүгээр факторын идэвхи тодорхойлох шинжилгээний арга технологи
6. Эмнэлзүйн удамзүй судлал
7. Эмнэлзүйн трансфузиологи
8. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараахь эмчилгээ, хяналт

**XX. Эмнэлзүйн дархлаа/харшил судлал:**

1. Харшлын оношилгоо, эмчилгээ
2. Бусад аутоиммуны эмгэгийн оношилгоо, эмчилгээ

**XXI. Сэргээн засал судлал**

1. Мэдрэлийн өвчин эмгэгийн үеийн сэргээн засах эмчилгээ
2. Зүрхний өвчин эмгэгийн үеийн сэргээн засах эмчилгээ
3. Хөлдөлт/тулэгдэлтийн дараахь үеийн сэргээн засах эмчилгээ
4. Хэл ярианы гажиг засал
5. Хараа зүйн гажиг засал
6. Хүүхдийн
7. Ахуй/ хөдөлмөр засал
8. Хоол эмчилгээ засал
9. Сонсголын гажиг засал

**XXII. Спортын анагаах ухаан судлал**

1. Спортын осол, гэмтлийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ/ сэргээн засах
2. Спортын сэтгэл судлал
3. Спортын хоол судлал

**XXIII. Бусад**

1. Эмнэлзүйн эм зүйч
2. Эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга зүй
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (инженер, техникч)
4. Эмнэлгийн барилгын архитектур, зураг төсөл, барилга байгууламжыг үнэлэх арга зүй
5. Зайн анагаах ухаан